



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 12 өдөр

Дугаар 9/332

Мандалговь

Г Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт
шилжүүлсэнтэй холбогдуулан авах зарим
арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.“а”, “ж”, “л”, 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.6, 39 дүгээр зүйлийн 39.1, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 178 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 12 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 19 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Гамшигаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан хот, аймаг, сум хоорондын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг Улсын Онцгой комиссын зөвшөөрснөөс бусад тохиолдолд 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 22:00 цагаас 11 дүгээр сарын 17-ны өдрийн 06:00 цаг хүртэл хугацаанд хязгаарласугай.

Хоёр. Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагууд /Засгийн газрын 2020 оны 178 дугаар тогтоолын хавсралтад зааснаас бусад/ хуулийн этгээдүүдийн үйл ажиллагааг 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 06:00 цаг хүртэл хугацаанд хориглосугай.

Гурав. Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хүн ам олноор цугларах газрууд болох барааны зах, худалдааны төв, сүм, хийд, баар, зоогийн газар, сургалтын төвүүд, спорт зал, фитнес, цахим тоглоомын газруудын үйл ажиллагааг 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 06:00 цаг хүртэл хугацаанд зогсоосугай.

Дөрөв. Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хүнс үйлдвэрлэл, худалдаа, түгээлтийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж, байгууллагын ажиллах цагийн хуваарийг 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрөөс 11 дүгээр сарын 17-ны өдрийн хугацаанд 09:00-21:00 цаг байхаар тогтоосугай.

Тав. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ж.Мөнхчuluун), Онцгой байдлын газар (М.Адьяабаатар), Цагдаагийн газар (Г.Наранбаатар), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), болон холбогдох байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, удирдлага, сумдын Засаг дарга наарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



482010916